



**СПОРТ ЗААЛНЫ ХАЛУУН УСНЫ ӨРӨӨНИЙ ЗАСВАРЫН ГЭРЭЭ**

Дугаар № .. 124 / 2022

20<sup>22</sup> оны 11 сарын 03 өдөр  
2022 он 12 сарын 08

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нөгөө талаас Ханахи ХХК-ийг төлөөлж захирал Н.Наранбаатар /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар ТБОНӨХБАҮХАТ хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2022 оны 5 дугаар

сарын 16-ны өдрийн А/104 дүгээр тушаал, Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, 2022 оны нийгмийн зардлын төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ”гэх) байгуулав.

**Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл**

1.1. Нийлүүлэгч нь “Спорт зааланд халуун усны өрөө хийхэд шаардлагатай” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасан барааг нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлж, угсарч, сууринуулж өгнө.

**Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа**

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулнаас хойш 20 /хорь/ хоногийн дотор багтаан нийлүүлж угсарч, сууринуулж өгнө.

**Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл**

3.1. Энэ гэрээний нийт үнэ 18,982,100 /арван найман сая есөн зуун наян хоёр мянга нэг зуу/-н төгрөг бөгөөд үнийн дунд гааль Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.

3.2. Гэрээт ажлын үнийн дүнгийн 50 /тавь/-н хувь болох 9,491,050 /есөн сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга тавь/-н төгрөгийг гэрээ баталгаажсан өдрөөс хойш 5/тав/ хоногийн дотор гүйцэтгэгчийн Хаан банкны 5540404875 тоот дансанд шилжүүлнэ. Гэрээт ажлын үлдэгдэл төлбөрийн 50 /тавь/-н хувь болох 9,491,050 /есөн сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга тавь/-н төгрөгийг барааг хүлээлгэн өгч, барааг угсарч сууринуулж гэрээ дүгнэсэн акт баталгаажуулнаар хойш 10 хоногийн дотор нэхэмжлэлийн дагуу гүйцэтгэгчийн Хаан банкны 5540404875 тоот дансанд шилжүүлнэ.

- 4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2. Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган узээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3. Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4. Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Барилга, сантехникийн инженер Б.Дуламсүрэн хариуцан ажиллана. Утас- 88015890.
- 4.5. Нийлүүлэгчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Ханахи ХХК-ийн захирал Н.Наранбаатар хариуцан ажиллана. Утас- 94560874.

#### **Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол**

- 5.1. Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2. Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэхээс хамгаалсан сав, баглаа боодлой байна.
- 5.3. Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энхүү гэрээгээр тодорхойлсон чанар стандартад нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4. Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж, засварлаж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5. Нийлүүлэгч нь нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн ажлыг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш **12** сарын баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл, доголдлыг баталгаат хугацаанд өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.

#### **Зургаа. Бараа хүлээн авах**

- 6.1. Нийлүүлэгчийн ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2. Нийлүүлэгч нь барааг Захиалагчид нийлүүлж, угсарч, суурилуулж хүлээлгэн өгөх бүх зардлыг хариуцна. Нийлүүлэгч нь дараах бичиг баримтыг хүлээлгэн өгнө.
 

Ажлын гүйцэтгэлийн тайлан	4хувь
Гэрээ дүгнэсэн протокол,акт	4хувь
Тухайн ажилтай холбоотой бусад акт баримтууд	4хувь
Угралтын өмнөх ба дараах ажлуудыг фото зургаар баримтжуулан хавсаргах	4хувь
Гарсан хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаяж баримтаар баталгаажуулах	4хувь

#### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг,байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж

гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.

7.2.Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 3 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

### **Найм. Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах.**

- 8.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.
- 8.2 Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцож нэмэлт өөрчлөлт оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй.
- 8.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр барааг нийлүүлэлгүй хугацаа хожимдуулсан, цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагчийн санаачилгаар гэрээг цуцална.
- 8.4 Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 10 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлана.
- 8.5 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.
- 8.6 Аль нэг тал гэрээг цуцлах тохиолдолд нөгөө талдаа 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

### **Ес. Бусад нөхцөл**

- 9.1.Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг бичгээр авсан тал хуанлийн 3 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2.Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3.Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4.Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5.Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 9.6.Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7.Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдэж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ  
Ө.УДВАЛ  
Гарын үсэг: 

**ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА**

Б.ГАНОЧИР  
Гарын үсэг: 

**ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Г.САРУУЛ**

Гарын үсэг: 

**ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Ш.ГАНТУЛГА**

Гарын үсэг: 

Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, Баянзурх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ХАНАХИ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Н.НАРАНБААТАР  
Гарын үсэг: 



Хаяг: УБ хот СБД 11-р хороо БЗНТ 80-6-3  
тоот  
Утас: 94560874,90656590  
РД: 3553892.



д/д	Материалын нэрс	хэмжих/н	тоо хэмжээ	нэгж үнэ	Нийт
<b>Нэг. Шалны материал</b>					
1	плита шалны /цагаан	ширхэг	18	16,500	297,000
2	Плитаны чигжээс	Уут	2	22,500	45,000
3	Плитаны хүрээ	ширхэг	4	16,500	66,000
4	Плитаны цавуу	шуудай	5	16,500	82,500
<b>Хоёр Таазны материал</b>					
1	Лампир	ширхэг	11	22,500	247,500
2	Лампир хүрээ	Ширхэг	8	16,000	128,000
3	Шрупп	хайрцааг	5	4,500	22,500
<b>Гурав. Гэрэлтуулэг цахилгаан хэрэгсэл</b>					
1	Кабель ПВЗ 4х6	м	50	20,000	1,000,000
2	Шруп	хайрцааг	2	16,000	32,000
3	Цахилгааны лент	ширхэг	1	5,500	5,500
4	Хар хоолой	багц	1	25,500	25,500
<b>Дөрөв. Бусад материал</b>					
1	Хаалга	ширхэг	2	520,000	1,040,000
2	Цемент	шуудай	2	25,000	50,000
3	лампир хана	ширхэг	12	41,000	492,000
4	Лампир хүрээ	ширхэг	5	15,000	75,000
5	Лампир булан / дотор гадн	ширхэг	15	15,000	225,000
6	Гипс хуурай	шуудай	1	80,000	80,000
7	шпатель	ширхэг	10	700	7,000
8	Хөөс	ширхэг	10	28,000	280,000
9	булан	ширхэг	5	1,700	8,500
10	Плитны шоо	уут	2	6,500	13,000
11	Плитаны зүсэгчийн ир	ширхэг	2	17,000	34,000
12	селекон	ширхэг	20	15,000	300,000
13	шуудай	боодол	1	77,000	77,000
14	бээлий	боодол	5	33,000	165,000
15	хурз	ширхэг	2	12,000	24,000
16	хурзний иш	ширхэг	2	3,500	7,000
17	Самтай опел	ширхэг	2	4,500	9,000
18	опел	ширхэг	5	11,000	55,000
19	Шрупп	уут	20	14,500	290,000
20	Бөмбөлгөн хаалт ф15	ширхэг	4	7,000	28,000

21	Дрель хошуу	хайрцаг	1	18,000	18,000
22	Таслагчийн ир	хайрцаг	1	25,000	25,000
23	Цаасны хутга	ш	5	8,800	44,000
24	Хутганы ир	ш	5	5,500	27,500
25	Өрөм 6 8	ш	10	2,500	25,000
26	Кнауф шруп	хайрцаг	20	17,500	350,000
27	Прусс 5x5	боодол	5	60,000	300,000
28	Квадрат төмөр 40x40	м	30	6,600	198,000
29	Агшин зуур халаагч	ком	4	1,200,000	4,800,000
30	Бохирын хоолой ф50	м	5	12000	60,000
31	Траф	ширхэг	4	28000	112,000
32	Тройник ф50	ширхэг	3	5200	15,600
33	Булан ф50	ширхэг	5	5200	26,000
34	Ус тусгаарлагч шингэн ши	ширхэг	2	160000	320,000
35	Гипс хавтан/ ногоон	ширхэг	4	35000	140,000
36	Хөшиг	ширхэг	4	36000	144,000
37	Өлгүүр	ширхэг	4	25000	100,000
38	Далдлагч/ кабель	ширхэг	2	5000	10,000
39	Тэлэгчтэй боолт	ширхэг	20	800	16,000
40	Материалын дүн /төг/				11,942,100
Тав. Ажлын хөлс					
41	Ажлын хөлс /төг/				7,040,000
42	Зардлын нийт дүн				<b>18,982,100</b>

Хянасан:

Эдийн засагч

*Э.Болортuya*

Боловсруулсан:

Хангамжийн мэрэгжилтэн



Ш.Гантулга